

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ
/ 2022 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР/

2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Гарсан үр дүн	Үнэлгээний ХУВЬ	Хяналтаас гаргах тухай санал дүгнэлттэй эсэх
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол						
1.3 Нутгийн захиргааны болон бусад албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд:						
18.	2018.07.09 №119 Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай	1.3.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага бүр өмчийн харъяалал үл хамааран орчны тохижилт, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, стандартын шаардлагыг баримтлан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, насанд	1. “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1033 дугаар захирамжаар Хотын стандартыг боловсруулах, батлуулах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгээс 9 бүлгийн 38 хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр хэлэлцүүлж НИТХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн. НИТХ-аар хэлэлцүүлэх ажлын хүрээнд: 2022 оны 03 дугаар сарын 21-ны өдөр Хот байгуулалт дэд бүтцийн хороо болон Зам тээвэр,	Хотын стандартын 9 бүлгийн 38 баримт бичгийг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 3 дугаар хуралд танилцуулж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барих тухай шийдвэр гарав.	70	Үгүй

		<p>хүрээгүй хүүхэд зэрэг онцгой анхаарал халамж шаардах иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангасан байх</p>	<p>хөдөлгөөн зохицуулалтын хорооны хамтарсан хурлаар 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал дахь Ардчилсан нам, Хөдөлмөрийн үндэсний намын бүлгүүдээр - 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Монгол ардын намын бүлгээр -2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 9 бүлгийн 38 баримт бичгийг тус тус хэлэлцүүлэн 100 хувийн саналаар дэмжигдэн батлуулав.</p> <p>2. Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах чиглэлээр 12 төрлийн судалгааг нийслэлийн 9 дүүрэгт 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл нийт 4651 байршилд судалгааг шинэчлэв. Үүнээс сайжруулах шаардлагатай 3598 байршлыг гаргаж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 3 дугаар хуралд танилцуулав. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) Хороо, өрхийн эмнэлгийн цогцолбор барилга хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын судалгаа - 124 2) Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчны судалгаа - 231 3) Хүүхдийн цэцэрлэгийн гадна орчны судалгаа -131 4) Хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдлын судалгаа - 923 5) Барилгын түр хашааны судалгаа - 185 6) Орц гарц хаасан байршлын судалгаа - 88 		
--	--	--	---	--	--

			<p>7) Ухсан нүх, овоолсон шороотой байршлын судалгаа - 45</p> <p>8) Нийтийн эзэмшлийн зам талбай болгон тохижуулах байршлын судалгаа - 35</p> <p>9) Барилгын ажил зогссон сургууль, цэцэрлэгийн судалгаа - 19</p> <p>10) Сууц өмчлөгчдийн холбооны гадна орчны судалгаа - 577</p> <p>11) Тээврийн хэрэгслийн ил зогсоолын судалгаа - 71</p> <p>12) Нийтийн тээврийн зогсоолын судалгаа – 1169</p> <p>3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.6 дахь заалтад туссан Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах стандартыг мөрдүүлэх зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Улаанбаатар хотын гэр хорооллын нүхэн жорлон нь “MNS 5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага”-ыг хангасан зориулалтын, стандартын зөв технологиор суурилуулсан эсэх талаарх судалгааг ирүүлэх тухай 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 01/69-01/75 дугаартай албан бичгийг хүргүүлэн Улаанбаатар хотын хэмжээнд 173463 өрхийн 133194 нүхэн жорлонгийн судалгаагаар байгууллагын мэдээллийн санд орон зайн мэдээг бүрдүүлэн ажиллаж байна. 		
--	--	--	---	--	--

			<ul style="list-style-type: none"> • Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй түүхий нүүрс түлдэг аж ахуйн нэгж байгууллагуудын судалгаа ирүүлэх тухай 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01/68 дугаартай албан бичгийг хүргүүлж, 73 аж ахуйн нэгж, байгууллагын зуухны судалгаагаар байгууллагын мэдээллийн санд орон зайн мэдээг үүсгэн ажиллав. 			
--	--	--	--	--	--	--

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Э.ДАВААХАТАН

НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



О.ӨНӨРБИЛЭГ